

## 1. Дадлагажигчид Япон улс дахь сургалтад оролцоно



Төр, ТББ, ААНБ-уудын төлөөллүүд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар суралцахаар Япон улсыг зорилоо

2-р сарын 8-наас 2-р сарын 19 хүртэл нийт 12 хоногийн хугацаанд төрийн болон ТББ-ын төлөөлөл, ААНБ-уудын хүний нөөцийн мэргэжилтнүүд, ажлын байрны дадлагажуулагчаар бэлтгэгдэж байгаа сургагч багш нараас бүрдсэн 17 дадлагажигч, 2 туслах ажилтан нар Япон улсаас зохион байгуулж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамрагдана.

Тус сургалт Ковидын улмаас өнгөрсөн жил цахимаар явагдсан бол энэ удаад хорио цээрийн дэглэм буурснаар оролцогчид Япон улсад очиж дадлагажих боломжтой болж байна.

Оролцогчид хөтөлбөрийн дагуу японы хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцооны талаар суралцах бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллагуудын үүрэг оролцоо

болон тэдгээрийн хамтын ажиллагааны арга туршлага, дэмжлэг үзүүлэх арга аргачлал, нөгү хуу зэрэгтэй газар дээр нь очиж танилцах юм. Сургалтад оролцогчид Монгол улсад буцаж ирээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулахад хамтран ажиллана.

Харин ажлын байрны дадлагажуулагчаар бэлтгэгдэж байгаа сургагч багш нар 2-р сарын 24 хүртэл Япон улсын Токио хотод үргэлжлүүлэн суралцах юм. Та бүхэн бидэнтэй хамт байж дараа дараачийн мэдээллийг цаг алдалгүй хүлээн аваарай.

## 2. DRUB2 ажилтан Мөнхтуул Японы ЖАЙКА-аас зохион байгуулдаг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” сэдэвчилсэн сургалтад оролцоод ирлээ

2023 оны 1-р сарын 12-ноос 2-р сарын 3-ны өдрүүдэд Япон улсын Нагоя хот дахь Жайка-Чүбү төвөөс зохион байгуулсан “ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” сургалтад DRUB2 төслийн ажилтан Мөнхтуул оролцоод ирсэн бөгөөд сургалтын талаар товч мэдээллийг хүргэж байгаа билээ

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх сургалт эхний 7 хоногт Япон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авах хүсэлтэй байгууллагуудад төрөөс үзүүлэх дэмжлэг, үйлчилгээг хэрхэн явуулдаг талаар танхимаар суралцсан.

Хөтөлбөрийн хоёр дахь 7 хоногоос эхлэн оролцогчид Нагоя хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгодог Соне Озонэ ашгийн бус байгууллага, Эй Жэй Юү-Вадачи Компьютер Хаус, Эй Жэй Юү-Комакари Вайн зэрэг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгодог байгууллагуудтай очиж танилцлаа.



Эй Жэй Юү-Вадачи Компьютер Хаус төвд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажилладаг ба санхүү бүртгэл, веб сайтын дизайн, дата мэдээлэл оруулах зэрэг ажлыг гэрээлэн гүйцэтгэдэг.



Сонэ Озонэ ашгийн бус байгууллага тус орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн халамжийн орон сууцийг хариуцаж мөн олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Нагоя нь боомт хот учир олон улсын худалдаа, үйлчилгээ зэрэг томоохон бизнес төвүүд мөн автомашины үйлдвэрлэл болон аж үйлдвэрийн бусад салбар өндөр хөгжсөн хот юм. Тиймээс ч энэ хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ууд нь бизнес, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр олон жилийн түүхэн туршлагатай байдгаараа онцлог ажээ.

Дараачийн мэдээгээр Нагоя хотын Тоёота автомашин үйлдвэрлэлийн салбар Тоёота-Лүүпс байгууллага болон жижиг дунд бизнесийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж байгаа туршлагын талаар танилцуулна.

### СЭДЭВ

1 Дадлагажигчид Япон улс дахь сургалтад оролцоно

2 DRUB2 ажилтан Мөнхтуул Японы ЖАЙКА-аас зохион байгуулдаг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” сэдэвчилсэн сургалтад оролцоод ирлээ

3 Япон улсын Нагоя хот дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч байгууллагууд ☉: Тоёота Моторс Корпорацитай танилцав

### 3. Япон улсын Нагоя хот дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч байгууллагууд ④: Тоёота Моторс Корпорацийтай танилцав



Зургаан орны оролцогчид Тоёота Кайкен Музей үзэв.

ААНБ-уудад нөлөөлөх нөлөөллийн багийн гишүүн Х.Батчимэг болон төслийн ажилтан Х.Мөнхтуул нар Япон улсын Нагоя хот дахь ЖАЙКА-Чүбү төвөөс ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрт хамрагдсан. Тус хөтөлбөрийн хүрээнд сургалтад оролцогч зургаан орны төлөөллүүд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг Япон улсын том корпораци болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгч зэрэг бизнесийн байгууллагуудтай танилцав.

Япон улсад ХБИ-дэд тэр дундаа ажил олоход хүндрэлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгож, хөдөлмөр эрхлэх орчин нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг олон компаниуд бий. Түүн дотроо автомашин үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Тоёота

Моторс Корпорацийн охин компани болох Тоёота Лүүпс компанийг онцлон танилцуулья.

Бидний зочилж очсон хамгийн том компани бол Япондоо төдийгүй дэлхийд танигдсан Тоёота Моторс Корпораци байлаа. Тоёота корпорацийн хувьд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг бодитоор хэрэгжүүлж улсдаа манлайлан Тоёота Лүүпс гэх охин компанийг байгуулан багагүй хүч гарган ажилладаг ажээ. Том корпораци юм чинь амархан байх гэж та бодож магадгүй юм. Компаниудын хувьд ашиг орлого чухал ч техник технологийн асар хурдтай хөгжил, ижил компаниудын өрсөлдөөнд ялгарах гол онцлог нь нийгмийн олон талт байдлыг ойлгож, хүлээн авч, түүнийгээ бизнес, менежментийн бодлогодоо уялдуулдаг нь Тоёота компаний давуу тал болов уу.



Тоёота Лүүпс компанид ажилладаг оюуны бэрхшээлтэй ажилтаны хийдэг ажил.

Тоёота Лүүпс нь корпорацийн хэмжээнд ажлын байрны үнэлгээ хийж ажил олоход хүндрэлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог, хэрэгцээнд тохирсон ажлын байрыг загварчлан гаргажээ.

Эдгээр загварчласан ажлууд нь тухайлсан нарийн мэргэжил шаардахгүй ч олон давтагддаг үйлдэлтэй оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс алдаа, магадгүй тууштай хийж чадах ажил байдаг. Үүнээс гадна Тоёота компанид ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөх сургалтыг корпорацийн хэмжээнд албан ёсоор зохион байгуулдаг. Тоёота корпораци ч энэхүү сургалтад ач холбогдол өгч сургалтын бааз, танхим, техник тоног төхөөрөмжүүдийг сайн бэлтгэсэн байдаг.



Оролцогчид Barrier-Free Mental сургалтын нэг хэсэг болох тэргэнцэртэй хүмүүст байнга тулгардаг саадуудыг өөрсдийн биеэр туршиж байна.

Мэдээж том корпораци учир хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан ажлын байр, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулахад асуудалгүй гэж бодож магадгүй. Тэгвэл бид та бүхэнд үйлдвэрлэл эрхэлдэг жижиг компани хүнд хэлбэрийн эрхэлдэг жижиг компани хүнд хэлбэрийн

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэрхэн ажиллуулж байгаа талаар дараачийн дугаараараа танилцуулна.



[dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5



<https://www.facebook.com/jicadpub1and2>



<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

